

“ДАЯН ДЭЛХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨӨ ХАМТ”-ДАА ЗҮТГЭХ АСУУДАЛ



Г.БУЯНТОГТОХ

ХСИС-ийн Удирдлагын сургуулийн Онцгой байдлын профессорын багийн профессор, Гамшиг судлалын докторант, Онцгой байдлын хурандаа

BUYANTOGTOKH G.

Professor of Senior Executive Institute, Law Enforcement University, Ph.D student, colonel

Товч агуулга: Хэдийнээс манай ард түмэн газар шилгээх, гал усны гашуун зовлон болж байсан гэдгийг амнаас ам дамжин ярьж, газар хөдлөлтийн аюулыг мэдэх л болсон ард түмэн. Газар хөдлөлтийг маш энгийн ойлголтоор тайлбарлахад “Чулуун мандлын хавтан”-гийн харилцан шилжилт хөдөлгөөн юм, тэдгээр нь холдон салах, ойртон нийлэх, дээгүүр доогуур шурган орох, нөгөө нь түүний дээгүүр тохогдохээр хөдөлгөөнөөр үүсдэг. Харин газар хөдлөлтийн хариу арга хэмжээний төлөвлөлт, бэлтгэл бэлэн байдлыг хангахад дан ганц улс орны хэмжээнд шийдвэрлэх асуудал биш юм.

Abstract : Earthquakes happen as large blocks of the Earth’s crust move suddenly past one another because of the force of plate tectonics.

Түлхүүр үг:

1. Номхон далай дахь АНУ-ын Хуурай замын цэрэг
2. Чулуун мандлын хавтан
3. Даян дэлхийн аюулгүй байдлын төлөө хамтдаа зүтгье

Key words:

1. United States’ Army Force in the Pacific Ocean
2. Board of Stone Layer
3. Lets’ endeavor together to secure the whole world

Удиртгал:

Хэдийгээр шинжлэх ухаан нотлож, батлаагүй ч онолоор хүнд зургаан мэдрэхүй эрхтэн байх боломжтой талаар сүүлийн үед судлаачид өгүүлэх болсон, харин миний хувьд ёстой л алаг хоёроороо харж, алгаараа тэмтэрч гурван мэдрэхүйгээрээ мэдрэснээ өнөөдрийг хүртэлх хугацаанд маш тодоор санадаг.

2011 оны 8 дугаар сарын 27-нд Улаанбаттар хотын цагаар өглөөний 8 цаг 29 минутад Өмнөговь аймгийн Ханхонгор сумын төвөөс зүүн хойш 28 км, Даланзадгад хотын төвөөс 58 км “УЛААН ТОЛГОЙ” гэдэг эзгүй тал хээр газарт 5,8

магнитудын хүчтэй газар хөдлөлт¹ болсон юм.

Тус аймгийн Засаг даргын дэмжлэг, хамт олныхоо идэвхи санаачлага, дотоод нөөц боломж, албан хаагчдынхаа ур чадварт тулгуурлан Онцгой байдлын албаны хэмжээнд бүсийн анхны Гамшгаас хамгаалах сургалтын төвийг барьж байгуулах ажил ид дундаа явагдаж 250-ын диаметрын төмөр хийцтэй 6 тулгуур труба баганыг 2,20 метр тутамд гагнуураар бэхлэж газрын гүнд 2,8 метрийг нь суулгаж бетондон 12 метрийн өндөртэй цамхагийн² орой нүүж байгаа үүлний эсрэг хөдөлгөөн хийгдэж маш богино хугацаанд дайвалзан төмөр, модон материал харшин чихрах чимээнээр газар хөдлөлт боллоо гэдгийг амьдралдаа анх удаа мэдэрч, сонсож, харсан.

ОРШИЛ

Судлагаа шинжилгээний байгууллагуудаас гаргасан тоо баримтаар жилд дунджаар дэлхий дээр 500 000 удаагийн газар хөдлөлт болж байдаг, үүнээс 100 000 орчим нь хүнд мэдрэгдэх буюу 3 магнитудаас дээш хэмжээний, харин эдгээрээс 100 гаруй нь хор уршиг, хохирол сүйрлийг дагуулсан гамшиг осол болдог гэсэн бүртгэл байна. Түүхэнд болж байсан хамгийн хүчтэй 10 удаагийн газар хөдлөлтөөр нийт 2 526 898 нас барж, хэдэн сая хүн ор сураггүй алга болж, бэртэж гэмтэн, орон гэргүй болсон³ юм билээ. Энэхүү тоо баримтад 2010 оны Гайти 316 000, 2011 оны Японы 15 883 хүнийг хамруулаагүй болно.

Тэгвэл Монгол улсад бүртгэгдсэн 1905 оны Говь-Алтай аймгийн Булнайн нуруунд 370 км урт хагарал үүсгэсэн 8 магнитуд, 1957 оны Баянхонгор аймгийн Богдын 8,1 магнитудыг өтгөс буурал маань “ Газар шилгээх, гал усны гашуун зовлон” болсон гэж амнаас ам дамжин ярьж, бид газар хөдлөлт гэдгийг мэдэх л болсон ард түмний нэг.

Маш энгийнээр газар хөдлөлтийг тайлбарлахад “Чулуун мандлын хавтан”-гийн харилцан шилжилт хөдөлгөөн юм, тэдгээр нь холдон салах, ойртон нийлэх, дээгүүр доогуур шурган орох, нөгөө нь түүний дээгүүр тохогдох хөдөлгөөнөөр үүсдэг⁴ гэдгийг Германы эрдэмтэн, цаг уурч Альфред Вегенер 1912 онд тив шилжин нүүх таамаглалаа дэвшүүлж олон судлаач, эрдэмтдийг хамарсан бүх судалгааны үр дүнд 1968 онд “Чулуун мандлын хавтангийн онол”-оор батлагдсан.

Монгол улсын Одон орон, геофизикийн хүрээлэнгийн Газар хөдлөлт судлалын секторын төвөөс сүүлийн жилүүдэд гаргасан судалгаагаар магнитуд нь 7-оос дээш хүчтэй газар хөдлөлт 30 гаруй удаа, магнитуд нь 8 дээш хүчтэй газар хөдлөлт 4 удаа өдөрт дунджаар 100 гаруй их, бага хэмжээний газар хөдлөлт бүртгэгдсэн ба зөвхөн 2015 он гарсаар эхний 3 сард 328 удаагийн тохиолдол, эдгээрээс улсын хүн амын 47% оршин суудаг бүсээс энүүхэн Эмээлтийн орчимд 188 удаа, Гүнтийн даваа орчимд газар хөдлөлтийн шинэ идэвхжил бүртгэгдэж 35 удаагийн чичирхийлэл, газар хөдлөлт бүртгэгдсэн тоо давтамж нь харангын дуу ойртож сонсогдон, хаалга нээгдэхгүй болоход бид яах ёстой вэ гэж сэтгэл чилээж, санаа зовоосон олон асуудлууд холбогдох мэргэжлийн байгууллагуудад тулгарах боллоо...

Дээрхи тоо баримтаас харахад аливаа улсын хөгжил, дэвшил дандаа ч дардан замаар санасан бодсоноор болдоггүйг түүхэн эх сурвалж, мөн амьдрал

¹ ОБХ-ийн Гамшгийн дүн бүртгэл, Өм.2011

² Гал унтраах олон төрөлт спортын стандарт УБ, 2010

³ Одон орон, геофизикийн хүрээлэнгийн Газар хөдлөлт судлалын секторын төвийн тайлан УБ. 2014

⁴ Гамшгийн эрсдэлийг үнэлэх арга зүй. УБ, 2010

Одон орон, геофизикийн хүрээлэнгийн Газар хөдлөлт судлалын секторын төвийн тайлан УБ. 2014

өөрөө харуулж байдагтай та санал нийлэх биз.

Энэхүү нийтлэлд дурьдагдсан эх сурвалж, тоо баримтаар олныг хирдхийлгэж, айлгах, сүрдүүлэх бодол миний хувьд байсангүй харин өнөөгийн уур амьсгалын хувьсан өөрчлөлт, техник технологийн хөгжил, хүний буруутай үйл ажиллагаа, экологийн тэнцвэрт байдал алдагдаж байгаа зэргээс нөхцөл байдал үүсэх, хамгийн сонирхолтой бас аюултай нь бид бүхэн үнэн хэнэггүй аливаа зүйлд төдийлэн ач холбогдол өгдөггүй байдал нь учирч болзошгүй эрсдэл, тааж баршгүй хэмжээний хохиролыг нэмэгдүүлэх магадлалтайг өгүүлэхэд илүүц болохгүй болов уу.

Амьдрал, ахуй дээр эрсдэлийг бүр ч үгүйсгэдэггүй юм билээ, тодорхой зөвшөөрөгдөх, “Хүлцэх хэмжээ” гэж байдаг тэгвэл бидний ойлгож, хүлцэх хэмжээ ямар түвшинд байгаад дүгнэлт хийцгээе.

БИД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БЭЛЭН ҮҮ?

Япон улсын Сэндай хотод НҮБ-ын Гамшгийн аюулыг бууруулах газраас 2015 оны 3 дугаар сард зохион байгуулсан Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон улсын хурлаас дэлхийн улс орнууд тэр дундаа Ази-Номхон далайн орнууд санаачлага гарган “Гамшгийн аюулгүй байдлын төлөө хамтдаа тэмцэх” уриалга⁵ гарган ажиллах боллоо.

Энэ нь дэлхий дахинаа тохиолдож болзошгүй гамшиг ослын хор уршгийг бууруулах, арилгах ажиллагаа даяаршлагдаж байгааг харуулсан үйл явдал юм.

Уг дээд хэмжээний хуралдааны үеэр байгуулагдсан түншлэл хамтын ажиллагааны баримт бичигт үзэглэсэн гарын үсэгний бэх хатаж ч амжаагүй шахуу байх хугацаанд Монгол улсын ОБЕГ, Номхон далай дахь АНУ-ын Хуурай замын цэрэг хамтран Олон улсын болон төр захиргаа, төрийн бус байгууллагын төлөөллийг хамруулан нийт 32 цагийн багтаамжтайгаар онол, практик ажиллагаанд тулгуурлан батлагдсан хөтөлбөрийн дагуу дасгал сургуулийг 3 сарын 24-27-ны өрдүүдэд амжилттай зохион байгуулсныг цохон тэмдэглэхэд таатай байна.

Туршлага солилцох дасгал сургууль нь гамшгийн өмнөх үеийн төлөвлөлт, аврах, хор уршгийг арилгах үеийн хүндрэл, цэрэг, хууль сахиулах - иргэний байгууллагуудын хамтын ажиллагаа, Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах үеийн зохицуулалтыг хангах ажиллагааг удирдлага болгон Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудал, Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг дээр Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэг хүлээсэн байгууллага, салбар дундын харилцан ажиллагааг харуулах, боловсронгуй болгох зорилго, зорилтод чиглэгдсэн үзүүлэх сургууль болж өнгөрлөө.

Туршлага солилцох сургуулийн явцад болзошгүй гамшиг, осол түүнчлэн газар хөдлөлтийн хариу арга хэмжээний төлөвлөлт, бэлтгэл бэлэн байдал, урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаа нь дан ганц улс орны хэмжээнд шийдвэрлэж, аливаа улс гүрэн аюулгүй байдлаа бүрэн хангах асуудал биш гэдгийг энэхүү дасгал сургуулилтаас мэдээллийг хангалттай ойлгож авлаа.

ҮР ДҮНГИЙН ТАЛААР

Мэдээж аливаа арга хэмжээ, үйл ажиллагааны ололт, учир дутагдлыг олж илрүүлэхийг шинжлэх ухаан онолоор баталжээ, иймд судлаачийн байр сууринаас ажиглалт, харьцуулалт, задлан шинжлэх, дедукцын гэх мэт аргаар тодорхойлон дасгал сургуулилтын явцаас давуу болон сул талыг харж үнэлэлт, дүгнэлт өгч чухамхүү үнэнийг цөөхөн хэдэн үгээр илэрхийлж байгаа нь дараа дараагийн

⁵ МУ-ын Шадар сайдын илтгэл. Япон 2015

зохион байгуулалтын арга хэмжээг боловсронгуй болгоход чиглэгдсэн гэдгийг уншигч авхай та тунгаах биз ээ.

Олон улсын төрөлжсөн байгууллагуудын сургагч багш, мэргэжилтнүүд хүрэлцэн ирж сургалтад Аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэгтэй байгууллагуудын албан хаагчид олноор хамрагдаж гамшгаас хамгаалах ажиллагаанд үүрэг, чиглэлийн дагуу багаар хамтран ажиллах ойлголт авсан.

Зохион байгуулагч хоёр талын сургууль удирдагч нар ажил алба, мэргэжлийн өндөр ур чадвартай, заах арга зүйн арга хэлбэрийг төгс эзэмшсэн, сургалтын хөтөлбөр, танхимын хичээлийн хэлбэрийг аль ч байгууллагын үйл ажиллагаанд тусгаж болохуйц шинэлэг, сонирхолтой үр дүнд хүрэх хэмжээнд зохион байгуулсан.

НҮБ-ын ложистикийн 12 төрлийн кластерын систем⁶ Монгол улсад нэвтэрч сургалтад хамрагдсан яам, агентлегийн суралцагч бүрэлдэхүүн нэгдсэн ойлголтод хүрч салбар дундын харилцан түншлэл, хамтын ажиллагааны хүрээнд гамшгийн голомтод багаар ажиллах зарчмыг сайтар ойлгосон бөлгөө.

Бусад улс орны ижил төстэй байгууллагуудын үйл ажиллагаатай хэрхэн уялдуулах, түүнчлэн Олон улсын байгууллагуудаас хүмүүнлэгийн тусламж авах талаар боломжийн түвшинд ойлголт авсан гэх мэт төрөөс ард иргэдэд шуурхай хүргэх ажил, үйлчилгээнд тусгах давуутай олон асуудлууд оршиж байв.

ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

Гамшиг ослын үед аврах, хор уршгийг арилгах арга хэмжээг тэргүүлэх чиг үүрэгтэйгээр оролцох Онцгой байдлын алба болон дэмжлэг үзүүлэх яам, агентлаг, “Чингис хаан” Олон улсын нисэх буудал зэрэг нь “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-нд сургуулийн өгөгдсөн цагийн байдалтай холбогдуулан ашиглах мэдээллүүдийг бүрэн тусгаагүй, сургалтад хамрагдсан бүрэлдэхүүн нь төлөвлөгөөгөө үйл ажиллагаанд удирдлага болгон ашиглаж хэвшээгүй;

Сургуульд оролцож байгаа бүрэлдэхүүн нь өөр өөрийн салбарын холбогдох хууль, журмыг сайтар судлаагүй нь багаар ажиллахад хүндрэл учруулж байсан ба тэдгээрийн оролцоо, идэвхи хангалтгүй. Тухайлбал: Бодлого боловсруулах хоёр яамнаас оролцсон төлөөлөл бүрэн хамрагдсангүй;

Улс орны дотоодын нөөц боломжоос давсан гамшиг ослын үед Олон улсын тусламжийг хүлээн авах үеийн үнэлгээ хийх, хилийн боомтоор гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлт хийх журмыг боловсруулаагүй;

“Чингис хаан” ОУНБ-ын Онцгой комиссын хурал зохион байгуулагдаж үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан цагийн байдлыг үнэлэх, асуудлыг боловсруулах, шийдвэр гаргах ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагаа оновчтой бус;

Улс орны хэмжээнд дотоодын нөөц боломжоос давсан гамшиг ослын үед Олон улсын тусламжийг хүлээн авах үед үнэлгээ хийх, хилийн боомтоор гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлт хийх журмыг боловсруулаагүй;

Нийслэл хотод учирч болзошгүй гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааны боломжоос давсан нөхцөл байдлын үед орон нутгаас мэргэжлийн байгууллагуудын хүч хэрэгслийг татан оролцуулах талаар Улаанбаатар хотын “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-нд тодорхой тусгаагүй;

Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг дээр явагдсан үзүүлэх сургууль удирдлага, зохион байгуулалт хангалтгүй явагдсан зэрэг энд дурьдагдсан зүйлүүд

⁶ Гамшгийн менежмент. Үржин.О, Алтанчимэг. УБ 2005 он

нь бодлого төлөвлөлт, зохион байгуулалтын асуудлууд ба гамшгаас хамгаалах чиг үүрэгтэй мэргэжлийн байгууллагаас хэрэгжүүлдэг хяналт шалгалт, дасгал сургуулилт хэрхэн, ямар түвшинд, ямар хэмжээнд зохион байгуулж явагдаг тавьсан дүн, үнэлэлт гэж би хувьдаа үзлээ.

Харин Гамшгийн эрсдэлийг бууруулах, арилгах үйл ажиллагааг судалгаа шинжилгээнд тулгуурлан Гамшиг судлалыг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам руу хөлгийн жолоог залж, төдийлэн дөрөө харшуулан давхиж чадахгүй байна уу гэсэн асуултын хариулт одоохондоо үлдлээ.

Мөн дасгал сургуулилын явцад тухайн тухайн сул бас алдаа оноотой асуудлууд байгаагаас үзэхэд бид болзошгүй гамшиг, осол түүнчлэн газар хөдлөлтийн хариу арга хэмжээний төлөвлөлт, бэлтгэл бэлэн байдлыг хангах асуудлаа төдийлэн хангаж чадахгүй байна гэсэн хариулт дээрх байдлуудаас урган гарч байгаа юм.

Хамгийн сонирхолтой нь ийм асуудлууд оршсоор байхад л санхүүжүүлэгч, зохион байгуулагч тал “Усыг нь уувал ёсыг нь дага” гэдэг үндэстний зан заншилд хөтлөгдөн “ОК, ОК” гэж үнэлгээ өгсөнд ажиглагчаар оролцсон миний хувьд дурамжхан л хоцорлоо.

ШИЙДВЭРЛЭХ АСУУДАЛ, АРГА ЗАМ

Оролцогсдыг сонгож сургалтад хамруулахдаа өмнөх зохион байгуулагдсан сургуулиудад оролцож байсан ажилтан, албан хаагчдыг ажил албаны дадлага туршлага, хэлний мэдлэг, улс орон, тухайн салбарынхаа нөхцөл байдлыг бусдад ойлгуулж чадах бүрэлдэхүүнийг хамруулах,

Туршлага солилцох “Говийн чоно” дасгал сургуулийг цаашид зохион байгуулагч, санхүүжүүлэгч талын сургалтын төв болон бодит нөхцөл байдлыг тулгуурлан явуулах боломжтой эсэхийг судлаж, харилцан хоёр талд зохион байгуулж байх асуудлыг тавих,

Сургалтын явцад ажиглалт хийхэд бодит нөхцөл байдал үүссэн үеийн хамгийн хүндрэлтэй асуудлуудаас сэтгэл зүйч нарын ажиллагаа дутагдаж байгааг мэдэрсэн тул Гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг сэтгэл судлаач мэргэжлээр бэлтгэх асуудлыг судлаж үзэх,

Гамшиг судлалын хүрээлэн, Стратегийн хүрээлэн, ХСИС, БХИС зэрэг судалгаа шинжилгээ, боловсролын байгууллага болон эрсдэлтэй үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн томоохон аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулах,

Нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжилд нөлөөлөхүйц, нөхцөл байдал үүсч хохирол, хор уршиг ихээр учирч болзошгүй эрсдэлтэй объектод суурилсан хяналт шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тодорхойлох гүйцэтгэлийн хяналт шалгалтад бусад мэргэжлийн холбогдох байгууллагуудын дэмжлэгийг авч хэрэгжүүлэх,

Улс орны хэмжээнд үүссэн нөхцөл байдлын тоог зөвхөн төвлөрүүлэн 10 гаруй жилийн хугацаанд хэвлэл мэдээллийн байгууллагуудыг мэдээ мэдээлэлээр тогтмол хангаж, тэд дурьдаад өнгөрч байгаа байдалд бид дүгнэлт хийх цаг болжээ, харин цаашид гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг хэрхэн, ямар арга зам хэлбэрээр, ямар бүтэц, удирдлага зохион байгуулалтайгаар бууруулах хамгийн оновчтой хувилбар, асуудлыг ОБЕГ-ын харьяа Гамшиг судлалын хүрээлэнгийн эрдэмтэн, судлаач нарын судалгаа шинжилгээний ажил, зөвлөмжид тулгуурлан онол арга зүйтэй нь уялдуулах талаар анхаарал хандуулах шаардлага байгааг нийтлэлд тусгая.

ДАЯН ДЭЛХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨӨ ХАМТДАА

Энэхүү туршлага солилцох, бэлэн байдлын чадавхийг үнэлэх дадлага сургуульд оролцож байгаа бүрэлдэхүүнд багахан хэмжээний мэдлэг, ур чадвар дутуу байлаа ч бидэнд болгоё, бүтээе гэсэн чин эрмэлзэл сэтгэлд минь гал мэт дүрэлзэж байхад л Үндэсний хэмжээнд аюулгүй байдал бүрэн хангагдах болно гэдэгт найдая.

Төгсгөлд нь судлаач миний дүгнэлтээр Монгол улсын төр захиргааны байгууллага болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн хэмжээнд Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны чиглэлийн хяналтын систем, хариуцлага тооцох бодит тогтолцоо ус,агаар мэт дутагдаж байгааг хэлж дуусгая.

Эшлэл авсан, ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Гамшгийн менежмент. ба дэвтэр. Үржин.О, Алтанчимэг.Ш нар УБ 2005 он
2. Монгол Улсын Их хурлын тогтоол 2010 оны 48 дугаар тогтоол. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.
3. Гамшгийн эрсдэлийг үнэлэх арга зүй. УБ, 2010
4. С.Хүрэлсүх нар “Цацрагийн ослын үеийн эрсдэлийн үнэлгээ ба шуурхай хариу арга хэмжээ” гарын авлага УБ. 2013.